

2026 ОНЫ 1 ДҮГЭЭР САР

## МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ БА БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

Д.Баярмаа<sup>1</sup>

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг Засгийн газар 2025 оны 9 дүгээр сарын 1-нд УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-иас уг хуулийг 2025 оны 11 дүгээр сарын 12-нд баталсан билээ. Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын 2026 төсвийн төсөл болон батлагдсан төсөвт туссан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд харьцуулсан дүн шинжилгээ хийж, тойм дүгнэлт боловсруулахад чиглэж байна.

**Төсвийн төсөлтэй харьцуулахад төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хэрэгжих нийт төсөл, арга хэмжээний тоо 159-өөр, нийт санхүүжих дүн 12.86 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан байна.**

Засгийн газар Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг 2025 оны 9 дүгээр сарын 1-нд УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-иас 2026 оны төсвийг 2025 оны 11 дүгээр сарын 12-нд баталжээ. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 11.1 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 3.28 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 738 хөрөнгө

оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр УИХ баталсан. Төсвийн төсөлтэй харьцуулахад нийт төсөл, арга хэмжээний тоо 159-өөр, нийт төсөвт өртөг 1.5 их наяд төгрөгөөр, 2026 онд олгох нийт санхүүжилтийн дүн 12.86 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгджээ.

### Хүснэгт 1. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээ

| Үзүүлэлт                       | 2026 оны төсвийн төсөлд туссан | 2026 оны төсөвт батлагдсан | Өөрчлөлт        |
|--------------------------------|--------------------------------|----------------------------|-----------------|
| Төслийн тоо                    | 579                            | 738                        | +159            |
| Төслүүдийн нийт төсөвт өртөг   | 9.63 их наяд ₮                 | 11.14 их наяд ₮            | +1.5 их наяд ₮  |
| 2026 оны олгох нийт санхүүжилт | 3.27 их наяд ₮                 | 3.28 их наяд ₮             | +12.86 тэрбум ₮ |

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

<sup>1</sup> Талархал: Тойм дүгнэлтэд санал, шүүмж өгсөн Нээлттэй Нийгэм форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадамд талархал илэрхийлж байна.

## ШИНЭЭР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

**Төсвийн төсөлтэй харьцуулахад шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 147-оор, нийт төсөвт өртөг 1.28 их наяд төгрөгөөр, 2026 онд олгох нийт санхүүжилтийн дүн 227.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагджээ.**

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 3.5 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 296 шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээг 1.3 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Төсвийн төсөлтэй харьцуулахад шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 147-оор (төсвийн төслөөс 8 төсөл, арга хэмжээ хасагдаж, шинээр 155 төсөл, арга хэмжээ нэмэгдсэн), нийт төсөвт өртөг 1.28 их наяд төгрөгөөр, 2026 онд олгох нийт санхүүжилтийн дүн 227.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан. Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийг эдийн засгийн ангиллаар авч үзвэл 2.68 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 732.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 175 барилга байгууламж, 687.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 499.8

тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 90 тоног төхөөрөмж, 98.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 43.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 19 их засвар, 35.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 26.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 7 техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), 33.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 11.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 цахим систем батлагджээ. Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн 75.8 хувийг барилга байгууламж, 19.5 хувийн тоног төхөөрөмж, 2.8 хувийг их засвар, 1 хувийг ТЭЗҮ, 0.9 хувийг цахим систем, нийт санхүүжилтийн 55.7 хувийг барилга байгууламж, 38.1 хувийг тоног төхөөрөмж, 3.3 хувийг их засвар, 2 хувийг ТЭЗҮ, 0.9 хувийг цахим систем тус тус эзэлж байна.

### **Хүснэгт 2. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар (тэрбум төгрөг)**

| Ангилал            | Төсөл, арга хэмжээний тоо |                  |          | Төсөвт өртөг  |                  |          | Төсөвт өртөгт эзлэх хувийн жин |                  | 2026 онд санхүүжих дүн |                  |          | 2026 онд санхүүжих дүнд эзлэх хувийн жин |                  |
|--------------------|---------------------------|------------------|----------|---------------|------------------|----------|--------------------------------|------------------|------------------------|------------------|----------|------------------------------------------|------------------|
|                    | Төсвийн төсөл             | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                  | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл          | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                            | Батлагдсан төсөв |
| Барилга байгууламж | 71                        | 175              | +104     | 1573.7        | 2678.9           | +1105.2  | 69.7%                          | 75.8%            | 507.1                  | 732.1            | +225     | 46.7%                                    | 55.7%            |
| Тоног төхөөрөмж    | 63                        | 90               | +27      | 521.4         | 687.7            | +166.3   | 23.1%                          | 19.5%            | 482.1                  | 499.8            | +17.7    | 44.4%                                    | 38.1%            |
| Их засвар          | 9                         | 19               | +10      | 77.4          | 98.3             | +20.9    | 3.4%                           | 2.8%             | 41.2                   | 43.8             | +2.6     | 3.8%                                     | 3.3%             |
| ТЭЗҮ               | 2                         | 7                | +5       | 52.2          | 35.5             | -16.7    | 2.3%                           | 1.0%             | 43.6                   | 26.4             | -17.2    | 4.0%                                     | 2.0%             |
| Цахим систем       | 4                         | 5                | +1       | 32.0          | 33.5             | +1.5     | 1.4%                           | 0.9%             | 11.4                   | 11.2             | -0.2     | 1.1%                                     | 0.9%             |
| Нийт               | 149                       | 296              | +147     | 2256.7        | 3534.0           | +1277.3  | 100%                           | 100%             | 1085.5                 | 1313.3           | +227.8   | 100%                                     | 100%             |

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль


**Зам, тээврийн сайдын шинээр хэрэгжүүлэх төслийн тоо, төсөвт өртөгт, 2026 онд олгох санхүүжилтийн дүн төсвийн төсөлтэй харьцуулахад хамгийн өндөр дүнгээр нэмэгдэж батлагджээ.**

Шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний тоогоор тэргүүлж буй 10 төсвийн ерөнхийлөн захирагчдад Боловсролын сайд, Зам, тээврийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Монгол Улсын Шадар сайд нар багтаж байна. Тухайлбал, Боловсролын сайд хамгийн олон буюу 63 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжүүлэх бол Зам, тээврийн сайд 42 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжүүлнэ.

Шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга

хэмжээний нийт төсөвт өртгийн 30.8 хувь Зам, тээврийн сайдад, 10.4 хувь Боловсролын сайдад, 10.2 хувь Эрчим хүчний сайдад, 10.1 хувь Эрүүл мэндийн сайдад, 8.3 хувь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад, үлдэх хувь нь бусад төсвийн ерөнхийлөн захирагчдад ногдож байна. Харин 2026 онд санхүүжих дүнгээр авч үзвэл нийт санхүүжих дүнгийн 18.8 хувь Зам, тээврийн сайдад, 15.6 хувь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад, 12.3 хувь Боловсролын сайдад, 9.1 хувь Эрүүл мэндийн сайдад, 7.1 хувь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад, 5.8 хувь Эрчим хүчний сайдад, 5.3 хувь Хууль зүй, дотоод хэргийн сайдад, үлдэх хувь нь бусад төсвийн ерөнхийлөн захирагчдад ногдож байна.

**Зураг 1. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний тоогоор тэргүүлж байгаа 10 төсвийн ерөнхийлөн захирагч (төслийн тоо)**



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

Зам, тээврийн сайдын шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөгт, санхүүжих дүн төсвийн төсөлтэй харьцуулахад хамгийн өндөр дүнгээр нэмэгдэж батлагдсан байна. Зам, тээврийн сайдын шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо 33-аар, нийт төсөвт өртөг 624.7 тэрбум төгрөгөөр, 2026 онд олгох нийт санхүүжилтийн дүн 139.5 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Мөн Боловсролын сайд,

Эрүүл мэндийн сайд, Эрчим хүчний сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд нарын шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо болон нийт төсөвт өртөг, 2026 онд олгох нийт санхүүжилтийн дүн нэмэгдсэн бол Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хувьд төсөл, арга хэмжээний тоо, нийт өртөг өссөн хэдий ч 2026 онд олгох нийт санхүүжилтийн дүн буурч батлагдсан байна.

**Хүснэгт 3. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн, Төсвийн ерөнхийлөн захирагчаар (тэрбум төгрөг)**

| Төсвийн ерөнхийлөн захирагч                                       | Төсөвт өртөг  |                  |          | Төсөвт өртөгт эзлэх хувийн жин |                  | 2026 онд санхүүжих дүн |                  |          | 2026 онд санхүүжих дүнд эзлэх хувийн жин |                  |
|-------------------------------------------------------------------|---------------|------------------|----------|--------------------------------|------------------|------------------------|------------------|----------|------------------------------------------|------------------|
|                                                                   | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                  | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл          | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                            | Батлагдсан төсөв |
| Зам, тээврийн сайд                                                | 464.5         | 1089.2           | +624.7   | 20.6%                          | 30.8%            | 108                    | 247.5            | +139.5   | 10.0%                                    | 18.8%            |
| Боловсролын сайд                                                  | 191.7         | 366.7            | +175     | 8.5%                           | 10.4%            | 103.1                  | 161.8            | +58.7    | 9.5%                                     | 12.3%            |
| Эрчим хүчний сайд                                                 | 304.7         | 359.1            | +54.4    | 13.5%                          | 10.2%            | 67.9                   | 76.5             | +8.6     | 6.3%                                     | 5.8%             |
| Эрүүл мэндийн сайд                                                | 328.4         | 358.3            | +29.9    | 14.6%                          | 10.1%            | 105                    | 120.1            | +15.1    | 9.7%                                     | 9.1%             |
| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд                     | 40.4          | 307.1            | +266.7   | 1.8%                           | 8.7%             | 22                     | 92.7             | +70.7    | 2.0%                                     | 7.1%             |
| Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд                     | 247.9         | 294              | +46.1    | 11.0%                          | 8.3%             | 246.4                  | 204.5            | -41.9    | 22.7%                                    | 15.6%            |
| Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд                  | 70.5          | 153              | +82.5    | 3.1%                           | 4.3%             | 25.2                   | 49.1             | +23.9    | 2.3%                                     | 3.7%             |
| Хууль зүй, дотоод хэргийн сайд                                    | 144           | 138.9            | -5.1     | 6.4%                           | 3.9%             | 79.3                   | 69.4             | -9.9     | 7.3%                                     | 5.3%             |
| Батлан хамгаалахын сайд                                           | 109.1         | 109.1            | -        | 4.8%                           | 3.1%             | 65.8                   | 60.9             | -4.9     | 6.1%                                     | 4.6%             |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд                       | 36.9          | 85.5             | +48.6    | 1.6%                           | 2.4%             | 23.2                   | 59.3             | +36.1    | 2.1%                                     | 4.5%             |
| Монгол Улсын Шадар сайд                                           | 70.9          | 73.7             | +2.8     | 3.1%                           | 2.1%             | 50.1                   | 46.1             | -4       | 4.6%                                     | 3.5%             |
| Сонгуулийн ерөнхий хорооны дарга                                  | 41.7          | 41.7             | 0        | 1.9%                           | 1.2%             | 12.5                   | 12.5             | -        | 1.2%                                     | 1.0%             |
| Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд | 72.5          | 39.4             | -33.1    | 3.2%                           | 1.1%             | 72.5                   | 39.4             | -33.1    | 6.7%                                     | 3.0%             |
| Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга       | 30.7          | 34.7             | +4.0     | 1.4%                           | 1.0%             | 12.1                   | 15.3             | +3.2     | 1.1%                                     | 1.2%             |
| Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд                     | 33.8          | 34.1             | +0.3     | 1.5%                           | 1.0%             | 23.8                   | 22.3             | -1.5     | 2.2%                                     | 1.7%             |
| Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд                       | 8.4           | 15.9             | +7.5     | 0.4%                           | 0.4%             | 8.4                    | 10.6             | +2.2     | 0.8%                                     | 0.8%             |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга                                   | 0.3           | 13.6             | +13.3    | 0.0%                           | 0.4%             | 0.3                    | 5.5              | +5.2     | 0.0%                                     | 0.4%             |
| Гадаад харилцааны сайд                                            | 19.9          | 9.9              | -10      | 0.9%                           | 0.3%             | 19.9                   | 9.9              | -10.0    | 1.8%                                     | 0.8%             |
| Сангийн сайд                                                      | 30            | 3.5              | -26.5    | 1.3%                           | 0.1%             | 30                     | 3.5              | -26.5    | 2.8%                                     | 0.3%             |
| Улсын ерөнхий прокурор                                            | -             | 3.3              | +3.3     |                                | 0.1%             | -                      | 3.3              | +3.3     |                                          | 0.3%             |
| Монгол Улсын Ерөнхий аудитор                                      | 2.5           | 1.3              | -1.2     | 0.1%                           | 0.0%             | 2.5                    | 1.3              | -1.2     | 0.2%                                     | 0.1%             |
| Авлигатай тэмцэх газрын дарга                                     | 1.7           | 1                | -0.7     | 0.1%                           | 0.0%             | 1.7                    | 1                | -0.7     | 0.2%                                     | 0.1%             |
| Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч                                  | 1.5           | 0.7              | -0.8     | 0.1%                           | 0.0%             | 1.5                    | 0.7              | -0.8     | 0.1%                                     | 0.1%             |
| Төрийн албаны зөвлөлийн дарга                                     | 0.4           | 0.2              | -0.2     | 0.0%                           | 0.0%             | 0.4                    | 0.2              | -0.2     | 0.0%                                     | 0.0%             |
| Монгол Улсын Их Хурлын дарга                                      | 3.6           | -                | -3.6     | 0.2%                           | -                | 3.6                    | -                | -3.6     | 0.3%                                     | -                |
| Монгол Улсын Ерөнхийлөгч                                          | 0.5           | -                | -0.5     | 0.0%                           | -                | 0.5                    | -                | -0.5     | 0.1%                                     | -                |


Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

### Аймгуудад шинээр хэрэгжих төслийн тоо, төсөвт өртөгт, 2026 онд олгох санхүүжилтийн дүн төсвийн төсөлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдэж батлагдсан.

Шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний тоог байршлаар нь авч үзвэл аймгуудад 147, Улаанбаатар хотод 82, “улсын хэмжээнд” буюу тодорхой байршил заагаагүй 40, Бүсүүдэд 27 төсөл, арга хэмжээ хэрэгжинэ. Шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн 37.8 хувь аймгуудад, 32.2 хувь Улаанбаатар хотод, 19.9 хувь бүсүүдэд, 10.1 хувь “улсын хэмжээнд” буюу тодорхой байршил заагаагүйгээр батлагджээ.

Харин 2026 онд олгох санхүүжилтийн дүнгээр авч үзвэл нийт санхүүжих дүнгийн 37.3 хувь Улаанбаатар хотод, 30.5 хувь аймгуудад, 18.7 хувь улсын хэмжээнд, 13.5 хувь бүсүүдэд ногдож байна. Төсвийн төсөлтэй харьцуулахад Улаанбаатар хотод шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 36-аар, нийт төсөвт өртөг 287.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт санхүүжих дүнд өөрчлөлт ороогүй байна.

**Зураг 2. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан төслийн тоо, байршлаар**



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

Аймгуудад шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 91-ээр, нийт төсөвт өртөг 642.3 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 191.1 тэрбум төгрөгөөр, бүсүүдэд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 20-оор, нийт төсөвт өртөг 416.9 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих

дүн 111.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагдсан. Улсын хэмжээнд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоонд өөрчлөлт ороогүй бөгөөд нийт төсөвт өртөг 69.6 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 74.4 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан байна.

**Хүснэгт 4. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжих төслийн төсөвт өртөг, санхүүжих дүн, байршлаар (тэрбум төгрөг)**

| Байршил        | Төсөвт өртөг  |                  |          | Төсөвт өртөгт эзлэх хувийн жин |                  | 2026 онд санхүүжих дүн |                  |          | 2026 онд санхүүжих дүнд эзлэх хувийн жин |                  |
|----------------|---------------|------------------|----------|--------------------------------|------------------|------------------------|------------------|----------|------------------------------------------|------------------|
|                | Төсвийн төсөл | Батлагдсан төсөл | Өөрчлөлт | Төсвийн төсөл                  | Батлагдсан төсөл | Төсвийн төсөл          | Батлагдсан төсөл | Өөрчлөлт | Төсвийн төсөл                            | Батлагдсан төсөл |
| Улаанбаатар    | 850.1         | 1137.9           | +287.8   | 37.7%                          | 32.2%            | 489.6                  | 489.6            | -        | 45.1%                                    | 37.3%            |
| Аймгуудад      | 695.0         | 1337.3           | +642.3   | 30.8%                          | 37.8%            | 209.3                  | 400.4            | +191.1   | 19.3%                                    | 30.5%            |
| Улсын хэмжээнд | 425.3         | 355.7            | -69.6    | 18.8%                          | 10.1%            | 319.9                  | 245.5            | -74.4    | 29.5%                                    | 18.7%            |
| Бүсүүдэд       | 286.2         | 703.1            | +416.9   | 12.7%                          | 19.9%            | 66.6                   | 177.8            | +111.2   | 6.1%                                     | 13.5%            |


Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

**Хан-Уул дүүрэгт шинээр хэрэгжих төслийн тоо, төсөвт өртөгт, 2026 онд олгох санхүүжилтийн дүн төсвийн төсөлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдэж батлагдсан бол Баянзүрх дүүрэгт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн буурч батлагджээ.**

Улаанбаатар хотод шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний тоог дүүргүүдээр авч үзвэл Чингэлтэй дүүрэгт 13, Баянгол дүүрэгт 12, Сүхбаатар дүүрэгт 11, Сонгинохайрхан дүүрэгт 8, Хан-Уул дүүрэгт 7, Баянзүрх дүүрэгт 4, Багануур дүүрэгт 1, Багахангай дүүрэгт 1 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Мөн хэрэгжих тодорхой дүүрэг заагаагүй нийслэлийн хэмжээнд хэрэгжих 25 төсөл, арга хэмжээ байна. Улаанбаатар хотод шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний нийт төсөвт

өртгийн 24.9 хувь Сонгинохайрхан дүүрэгт, 22.4 хувь хэрэгжих тодорхой дүүрэг заагаагүй төсөл, арга хэмжээнд, 19.3 хувь Хан-Уул дүүрэгт, 18.2 хувь Баянзүрх дүүрэгт ногдож, бусад дүүргүүдэд харьцангуй бага хувь ногдож байна. Харин 2026 онд санхүүжих дүнгээр авч үзвэл нийт санхүүжих дүнгийн 36 хувь хэрэгжих тодорхой дүүрэг заагаагүй төсөл, арга хэмжээнд, 26 хувь Баянзүрх дүүрэгт, 11.5 хувь Сонгинохайрхан дүүрэгт, 11.3 хувь Хан-Уул дүүрэгт ногдож, бусад дүүргүүдэд харьцангуй бага хувь ногдож байна.

**Зураг 3. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан төслийн тоо, дүүргээр**



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

Төсвийн төсөлтэй харьцуулахад Хан-Уул дүүрэгт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 4-өөр, нийт төсөвт өртөг 201.5 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 49 тэрбум төгрөгөөр, Баянгол дүүрэгт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 8-аар, нийт төсөвт өртөг, 29.8 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 9.6 тэрбум төгрөгөөр, Чингэлтэй дүүрэгт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 7-оор, нийт төсөвт өртөг 15.2 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 6.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагдсан. Харин Баянзүрх дүүрэгт шинээр

хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг 14.3 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 67.3 тэрбум төгрөгөөр буурч батлагджээ. Сүхбаатар дүүрэгт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 3-аар, нийт төсөвт өртөг 1.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ч нийт санхүүжих дүн 1.6 тэрбум төгрөгөөр буурсан. Мөн төсвийн төсөлд Багахангай дүүрэгт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ төлөвлөөгүй байсан бол 18.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2.5 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээ нэмж баталсан байна.

**Хүснэгт 5. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр Улаанбаатар хотод шинээр хэрэгжих төслийн төсөвт өртөг, санхүүжих дүн, дүүргээр (тэрбум төгрөг)**

| Байршил        | Төсөвт өртөг  |                  |          | Төсөвт өртөгт эзлэх хувийн жин |                  | 2026 онд санхүүжих дүн |                  |          | 2026 онд санхүүжих дүнд эзлэх хувийн жин |                  |
|----------------|---------------|------------------|----------|--------------------------------|------------------|------------------------|------------------|----------|------------------------------------------|------------------|
|                | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                  | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл          | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                            | Батлагдсан төсөв |
| Сонгинохайрхан | 266.1         | 283.6            | +17.5    | 31.3%                          | 24.9%            | 50.1                   | 56.4             | +6.3     | 10.2%                                    | 11.5%            |
| Нийслэл*       | 236.7         | 255.0            | +18.3    | 27.8%                          | 22.4%            | 180.8                  | 176.2            | -4.6     | 36.9%                                    | 36.0%            |
| Хан-Уул        | 18.7          | 220.2            | +201.5   | 2.2%                           | 19.3%            | 6.4                    | 55.4             | +49      | 1.3%                                     | 11.3%            |
| Баянзүрх       | 221.9         | 207.6            | -14.3    | 26.1%                          | 18.2%            | 194.4                  | 127.1            | -67.3    | 39.7%                                    | 26.0%            |
| Баянгол        | 54.7          | 84.5             | +29.8    | 6.4%                           | 7.4%             | 21.8                   | 31.4             | +9.6     | 4.5%                                     | 6.4%             |
| Чингэлтэй      | 20.6          | 35.8             | +15.2    | 2.4%                           | 3.1%             | 20.6                   | 26.8             | +6.2     | 4.2%                                     | 5.5%             |
| Сүхбаатар      | 27.1          | 28.9             | +1.8     | 3.2%                           | 2.5%             | 13.7                   | 12.1             | -1.6     | 2.8%                                     | 2.5%             |
| Багахангай     | -             | 18.1             | +18.1    | -                              | 1.6%             | -                      | 2.5              | +2.5     | -                                        | 0.5%             |
| Багануур       | 4.3           | 4.3              | -        | 0.5%                           | 0.4%             | 1.9                    | 1.6              | -0.3     | 0.4%                                     | 0.3%             |

\*Хэрэгжих тодорхой дүүрэг заагаагүй төсөл, арга хэмжээ

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль


**Дорнод, Архангай, Өвөрхангай, Увс аймгуудад шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг, санхүүжих дүн төсвийн төсөлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдэж батлагдсан.**

Шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний тоогоор Хөвсгөл, Баян-Өлгий, Архангай, Ховд, Өвөрхангай, Хэнтий аймгууд тэргүүлж байна. Тухайлбал, Архангай аймагт 18, Баян-Өлгий аймагт 14, Архангай аймагт 13, Ховд аймагт 12, Өвөрхангай аймагт 10, Хэнтий аймагт 10 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжихээр батлагдсан.

Аймгуудад шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн 12.6 хувь Ховд аймагт, 9.9 хувь Өвөрхангай аймагт, 9.4 хувь Дорнод аймагт, 8.2 хувь Архангай аймагт, 8.2 хувь Өмнөговь аймагт, 8.1 хувь Хөвсгөл аймагт, 5.8 хувь Увс аймагт ногдож, бусад аймгуудад 5 хувиас бага хувь ногдож байна.



**Зураг 4. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжихээр батлагдсан төслийн тоо, аймагаар**



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

Харин 2026 онд санхүүжих дүнгээр авч үзвэл нийт санхүүжилтийн 12.3 хувь Өвөрхангай аймагт, 10.8 хувь Дорнод аймагт, 10.4 хувь Ховд аймагт, 8.6 хувь Хөвсгөл аймагт, 7.3 хувь Архангай аймагт, 6.4 хувь Увс аймагт, 5.1 хувь Завхан аймагт ногдож, бусад аймгуудад 5 хувиас бага хувь ногдож байна.

Төсвийн төсөлтэй харьцуулахад Дорнод аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 7-оор, нийт төсөвт өртөг 98.4 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 35.3 тэрбум төгрөгөөр, Архангай аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 11-ээр, нийт төсөвт өртөг 96.5 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 24.9 тэрбум төгрөгөөр, Өвөрхангай аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 7-оор, нийт төсөвт өртөгт 89.9 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 23.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан. Мөн Увс аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 6-аар, нийт төсөвт өртөг 64.8 тэрбум төгрөгөөр,

нийт санхүүжих дүн 19.9 тэрбум төгрөгөөр, Говь-Алтай аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 4-өөр, нийт төсөвт өртөг 45.1 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 6. Тэрбум төгрөгөөр, Хөвсгөл аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 11-ээр, нийт төсөвт өртөг 41.4 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 14.4 тэрбум төгрөгөөр, Ховд аймагт шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний тоо 6-аар, нийт төсөвт өртөг 34.8 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 16.6 тэрбум төгрөгөөр, Завхан аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 1-ээр, нийт төсөвт өртөг 30.2 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 7.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан. Баян-Өлгий аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 10-аар, нийт төсөвт өртөг 24.4 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 9.1 тэрбум төгрөгөөр, Сүхбаатар аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 4-өөр, нийт төсөвт өртөг 23.8 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 6.8 тэрбум төгрөгөөр,



Дорноговь аймагт шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний тоо 3-аар, нийт төсөвт өртөг 17.3 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 5.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагдсан. Харин шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний санхүүжих дүн Өмнөговь аймагт 3.1 тэрбум төгрөгөөр, Говьсүмбэр аймагт 2.8 тэрбум төгрөгөөр, Дархан-Уул аймагт 0.2 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан.

Мөн төсвийн төсөлд Хэнтий, Орхон аймгуудад шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ төлөвлөөгүй байсан бол Хэнтий аймагт 25.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 12.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 10 төсөл, арга хэмжээ, Орхон аймагт 25.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 8.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээг УИХ-аас, нэмж баталсан байна.

**Хүснэгт 6. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр аймгуудад шинээр хэрэгжих төслийн төсөвт өртөг, санхүүжих дүн (тэрбум төгрөг)**

| Аймаг                                                                                      | Төсөвт өртөг  |                  |          | Төсөвт өртөгт эзлэх хувийн жин |                  | 2026 онд санхүүжих дүн |                  |          | 2026 онд санхүүжих дүнд эзлэх хувийн жин |                  |
|--------------------------------------------------------------------------------------------|---------------|------------------|----------|--------------------------------|------------------|------------------------|------------------|----------|------------------------------------------|------------------|
|                                                                                            | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                  | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл          | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                            | Батлагдсан төсөв |
| Ховд                                                                                       | 134.3         | 169.1            | +34.8    | 19.3%                          | 12.6%            | 25.2                   | 41.8             | +16.6    | 12.0%                                    | 10.4%            |
| Өвөрхангай                                                                                 | 42.5          | 132.4            | +89.9    | 6.1%                           | 9.9%             | 25.9                   | 49.4             | +23.5    | 12.4%                                    | 12.3%            |
| Дорнод                                                                                     | 26.9          | 125.3            | +98.4    | 3.9%                           | 9.4%             | 7.9                    | 43.2             | +35.3    | 3.8%                                     | 10.8%            |
| Архангай                                                                                   | 13.5          | 110              | +96.5    | 1.9%                           | 8.2%             | 4.5                    | 29.4             | +24.9    | 2.2%                                     | 7.3%             |
| Өмнөговь                                                                                   | 106.9         | 109.4            | +2.5     | 15.4%                          | 8.2%             | 20                     | 16.9             | -3.1     | 9.6%                                     | 4.2%             |
| Хөвсгөл                                                                                    | 66.8          | 108.2            | +41.4    | 9.6%                           | 8.1%             | 20.1                   | 34.5             | +14.4    | 9.6%                                     | 8.6%             |
| Увс                                                                                        | 12.3          | 77.1             | +64.8    | 1.8%                           | 5.8%             | 5.6                    | 25.5             | +19.9    | 2.7%                                     | 6.4%             |
| Говь-Алтай                                                                                 | 17.9          | 63               | +45.1    | 2.6%                           | 4.7%             | 6.7                    | 13.3             | +6.6     | 3.2%                                     | 3.3%             |
| Дундговь                                                                                   | 53.4          | 62.9             | +9.5     | 7.7%                           | 4.7%             | 9.4                    | 11               | +1.6     | 4.5%                                     | 2.7%             |
| Булган                                                                                     | 50.4          | 60.1             | +9.7     | 7.2%                           | 4.5%             | 12.5                   | 14.2             | +1.7     | 6.0%                                     | 3.6%             |
| Завхан                                                                                     | 28.6          | 58.8             | +30.2    | 4.1%                           | 4.4%             | 12.9                   | 20.4             | +7.5     | 6.2%                                     | 5.1%             |
| Баян-Өлгий                                                                                 | 20.5          | 44.9             | +24.4    | 2.9%                           | 3.4%             | 8.2                    | 17.3             | +9.1     | 3.9%                                     | 4.3%             |
| Дорноговь                                                                                  | 22.3          | 39.6             | +17.3    | 3.2%                           | 3.0%             | 10                     | 15.6             | +5.6     | 4.8%                                     | 3.9%             |
| Говьсүмбэр                                                                                 | 38.9          | 38.9             | -        | 5.6%                           | 2.9%             | 16.5                   | 13.7             | -2.8     | 7.9%                                     | 3.4%             |
| Сүхбаатар                                                                                  | 13.5          | 37.3             | +23.8    | 1.9%                           | 2.8%             | 6.1                    | 12.9             | +6.8     | 2.9%                                     | 3.2%             |
| Хэнтий                                                                                     | 0             | 25.7             | +25.7    | 0                              | 1.9%             | -                      | 12.4             | +12.4    | -                                        | 3.1%             |
| Орхон                                                                                      | 0             | 25.2             | +25.2    | 0                              | 1.9%             | -                      | 8.2              | +8.2     | -                                        | 2.0%             |
| Баянхонгор                                                                                 | 13.2          | 19.7             | +6.5     | 1.9%                           | 1.5%             | 6.1                    | 6.7              | +0.6     | 2.9%                                     | 1.7%             |
| Сэлэнгэ                                                                                    | 12.5          | 13.7             | +1.2     | 1.8%                           | 1.0%             | 4.6                    | 5.1              | +0.5     | 2.2%                                     | 1.3%             |
| Төв                                                                                        | 4.6           | 7.5              | +2.9     | 0.7%                           | 0.6%             | 2.1                    | 2.9              | +0.8     | 1.0%                                     | 0.7%             |
| Увс, Завхан, Ховд, Говь-Алтай                                                              | -             | 4.5              | +4.5     | -                              | 0.3%             | -                      | 4.5              | +4.5     | -                                        | 1.1%             |
| Дархан-уул                                                                                 | 3.6           | 3.6              | -        | 0.5%                           | 0.3%             | 1.1                    | 0.9              | -0.2     | 0.5%                                     | 0.2%             |
| Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд | -             | 0.4              | +0.4     | -                              | 0.0%             | 0.4                    | 0.4              | -        | 0.2%                                     | 0.1%             |
| Архангай, Өвөрхангай                                                                       | 12.2          | 0                | -12.2    | 1.7%                           | -                | 3.6                    | -                | -3.6     | 1.7%                                     | -                |

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

### **Төсвийн төсөлд шинээр хэрэгжихээр туссан байсан боловч батлагдаагүй хасагдсан 8 төсөл, арга хэмжээ байна.**

Төсвийн төсөлд шинээр хэрэгжихээр туссан байсан боловч батлагдаагүй хасагдсан нийт 74.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 47 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 8 төсөл, арга хэмжээ байна. Үүнд, 23 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй Татварын мэдээллийн системийн дэд бүтэц, серверийн болон татварын албадын тоног төхөөрөмж, 22.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 10 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Замын-Үүд талаас Сайншанд чиглэлийн 16 км хатуу хучилттай замын хэсэгчилсэн их засвар, 10.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 3.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж

багтжээ. Мөн 9.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн эмнэлгийн барилга, 3.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж, 3.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, 1.4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Ховд аймгийн Буянт сумын спорт заалны барилга, 2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй Үндэсний аудитын газрын тоног төхөөрөмж, 0.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй Ерөнхийлөгчийн Тамгын газрын тоног төхөөрөмж батлагдаагүй хасагдсан байна (Хавсралт 1).

### **Төсвийн төсөлд тусгаагүй байсан 155 шинэ төслийг УИХ-аас нэмж баталсан байна.**

Төсвийн төсөлд тусгаагүй байсан ч нэмж батлагдсан шинээр хэрэгжих нийт 1.43 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 469.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 155 төсөл, арга хэмжээ байна (Хавсралт 2). Эдгээрээс хамгийн өндөр төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй төслүүдийг дурдвал, 231 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 20.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замын 2 дугаар хэсэг, 178.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 36 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Байгалийн түүхийн музейн үзүүлэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмжийн төсөл нэмж батлагджээ. Мөн 59.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 19.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, Чойбалсан нисэх буудал (Аэродром)-ын хөөрч, буух зурвас, шинэчлэх төсөл, 45.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 15 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Баянхонгор-Архангай аймгийн Чулуут сум хүртэлх хатуу

хучилттай авто замын эхлэл, 44.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Онги-Цагаан бургастай төсөл, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нэмж батлагдсан байна. Түүнчлэн, 30 тэрбум төгрөгийн ижил төсөвт өртөг ба 10 тэрбум төгрөгийн ижил санхүүжих дүнтэй 4 авто замын төсөл нэмэгдэж батлагджээ. Үүнд, Арвайхээр-Баянхонгор чиглэлийн авто замаас Уянга сум хүртэлх 50 км хатуу хучилттай авто замын эхлэл, Босоо тэнхлэгийн авто замын Арвайхээр - Богд сум чиглэлийн 170 км хатуу хучилттай авто замын эхлэл, Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн 164.5 км хатуу хучилттай авто замын эхлэл, Хархорин, Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Батцэнгэл чиглэлд баригдаж байгаа замын төгсгөлөөс хүүхдийн Тамир зуслан-Батцэнгэл сумын төмөр бетон гүүр, мянганы замын хэвтээ тэнхлэгтэй холбох 62.04 км хатуу хучилттай авто замын эхлэл төслүүд багтаж байна.

**Хүснэгт 7. Төсвийн төсөлд тусаагүй боловч шинээр хэрэгжихээр нэмэгдэж батлагдсан хамгийн өндөр төсөвт өртөгтэй төслүүд (тэрбум төгрөг)**

| №  | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил                                                                                                                                                                                                                 | Төсөвт өртөг | 2026 онд санхүүжих дүн |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|------------------------|
| 1  | Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замын 2 дугаар хэсэг, 100.21 км (Говийн бүс)                                                                                                                                         | 231.0        | 20.1                   |
| 2  | Байгалийн түүхийн музейн үзүүлэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)                                                                                                               | 78.4         | 36.0                   |
| 3  | Чойбалсан нисэх буудал (Аэродром)-ын хөөрч, буух зурвас, шинэчлэх (Дорнод, Хэрлэн сум)                                                                                                                                                                          | 59.1         | 19.7                   |
| 4  | Баянхонгор-Архангай аймгийн Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл (Хангайн бүс)                                                                                                                                                                   | 45.9         | 15.0                   |
| 5  | Онги-Цагаан бургастай төсөл, төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв (Өвөрхангай, Уянга, Зүүнбаян-Улаан сум, Өмнөговь, Мандал-Овоо сум, Улаан нуур)                                                                                                 | 44.5         | 9.0                    |
| 6  | Үерийн далан (Говь-Алтай, Есөнбулаг сум)                                                                                                                                                                                                                        | 30.9         | 5.0                    |
| 7  | Баянхонгор-Говь-Алтай чиглэлийн авто замаас Шинэжинст сум хүртэлх 204 км хатуу хучилттай авто замын эхлэл (Хангайн бүс)                                                                                                                                         | 30.3         | 10.0                   |
| 8  | Дулааны станцын 1, 2 дугаар хэлхээний гадна дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл (Завхан, Тосонцэнгэл сум)                                                                                                                                                | 30.2         | 10.0                   |
| 9  | Арвайхээр-Баянхонгор чиглэлийн авто замаас Уянга сум хүртэлх 50 км хатуу хучилттай авто замын эхлэл (Хангайн бүс)                                                                                                                                               | 30.0         | 10.0                   |
| 10 | Босоо тэнхлэгийн авто замын Арвайхээр - Богд сум чиглэлийн 170 км хатуу хучилттай авто замын эхлэл (Өвөрхангай)                                                                                                                                                 | 30.0         | 10.0                   |
| 11 | Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн 164.5 км хатуу хучилттай авто замын эхлэл (Увс)                                                                                                               | 30.0         | 10.0                   |
| 12 | Хархорин, Цэцэрлэг чиглэлийн А0602 дугаартай авто замаас Батцэнгэл чиглэлд баригдаж байгаа замын төгсгөлөөс хүүхдийн Тамир зуслан-Батцэнгэл сумын төмөр бетон гүүр, мянганы замын хэвтээ тэнхлэгтэй холбох 62.04 км хатуу хучилттай авто замын эхлэл (Архангай) | 30.0         | 10.0                   |
| 13 | Ногоон хот-Тогтвортой хөгжлийн дэд бүтцийн төсөл (Баруун бүс)                                                                                                                                                                                                   | 30.0         | 20.0                   |

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

Төсвийн төсөлд тусгаагүй байсан ч нэмж батлагдсан шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл Зам, тээврийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Боловсролын сайд нарт хамгийн хамгийн олон төсөл, арга хэмжээ нэмэгдэж батлагдсан байна. Зам, тээврийн сайдад 647 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 171.3 тэрбум төгрөгийн

санхүүжих дүнтэй, 34 төсөл, арга хэмжээ, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад 269.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 73.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 21 төсөл, арга хэмжээ, Боловсролын сайдад 184.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 69.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 32 төсөл, арга хэмжээ нэмэгдэж батлагджээ.

**Хүснэгт 8. Төсвийн төсөлд тусаагүй боловч шинээр хэрэгжихээр нэмэгдэж батлагдсан төслүүд, төсвийн ерөнхийлөн захирагчаар (тэрбум төгрөг)**

| Төсвийн ерөнхийлөн захирагч                                       | Төсөл, арга хэмжээний тоо | Төсөвт өртөг | 2026 онд санхүүжих дүн |
|-------------------------------------------------------------------|---------------------------|--------------|------------------------|
| Зам, тээврийн сайд                                                | 34                        | 647.0        | 171.3                  |
| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд                     | 21                        | 269.8        | 73.9                   |
| Боловсролын сайд                                                  | 32                        | 184.2        | 69.2                   |
| Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд                  | 12                        | 92.9         | 30.8                   |
| Эрчим хүчний сайд                                                 | 6                         | 54.4         | 18.8                   |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд                       | 12                        | 51.4         | 40.2                   |
| Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд                     | 3                         | 46.2         | 10.7                   |
| Эрүүл мэндийн сайд                                                | 12                        | 29.9         | 22.5                   |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга                                   | 1                         | 13.4         | 5.3                    |
| Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд                       | 6                         | 11.7         | 6.4                    |
| Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга       | 6                         | 8.8          | 8.8                    |
| Монгол Улсын Шадар сайд                                           | 2                         | 7.9          | 2.7                    |
| Улсын ерөнхий прокурор                                            | 2                         | 3.3          | 3.3                    |
| Хууль зүй, дотоод хэргийн сайд                                    | 3                         | 3.2          | 3.2                    |
| Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд                     | 2                         | 3.0          | 1.9                    |
| Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд | 1                         | 0.7          | 0.7                    |

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

**Төсвийн төсөлд туссан шинээр хэрэгжих 92 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг эсвэл 2026 онд олгох санхүүжилтийн дүнд өөрчлөлт орж батлагджээ.**

Төсвийн төсөлд туссан төсөвт өртөг эсвэл санхүүжих дүнд өөрчлөлт орж батлагдсан шинээр хэрэгжих 92 төсөл, арга хэмжээ байна. (Хавсралт 3). Эдгээр 92 төсөл, арга хэмжээний санхүүжих дүн бүгд өөрчлөгдсөн ба 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэж, 18 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг буурч батлагдсан. Төсөвт өртөг ба санхүүжих дүнд өндөр дүнтэй өөрчлөлт орсон төсөл, арга хэмжээнүүдээс дурдвал, Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний төсөвт өртөг ба санхүүжих дүн 19.6 тэрбум төгрөгөөр,

Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн төсөвт өртөг ба санхүүжих дүн 14.3 тэрбум төгрөгөөр, Гадаад харилцааны салбарын тоног төхөөрөмжийн төсөвт өртөг ба санхүүжих дүн 9.9 тэрбум төгрөгөөр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмжийн төсөвт өртөг ба санхүүжих дүн 5.6 тэрбум төгрөгөөр, Стандарт, хэмжил зүйн салбарын улсын эталон болон хүнсний лабораториудын багаж, тоног төхөөрөмжийн төсөвт өртөг ба санхүүжих дүн 5.2 тэрбум төгрөгөөр тус тус буурч батлагдсан байна.

**Хүснэгт 9. Төсвийн төсөлд туссан төсөвт өртөг ба 2026 онд олгох санхүүжилтийн дүнд хамгийн их өөрчлөлт орж батлагдсан шинээр хэрэгжих төслүүд (тэрбум төгрөг)**

| № | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил                                                                                              | Төсөвт өртөг  |                  |          | 2026 онд олгох санхүүжилтийн дүн |                  |          |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|------------------|----------|----------------------------------|------------------|----------|
|   |                                                                                                                                              | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                    | Батлагдсан төсөв | Өөрчлөлт |
| 1 | Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ (Улсын хэмжээнд) | 40.0          | 20.4             | -19.6    | 40.0                             | 20.4             | -19.6    |
| 2 | Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)                                  | 32.5          | 18.3             | -14.3    | 32.5                             | 18.3             | -14.3    |
| 3 | Гадаад харилцааны салбарын тоног төхөөрөмж (Улаанбаатар)                                                                                     | 19.9          | 9.9              | -9.9     | 19.9                             | 9.9              | -9.9     |
| 4 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж (Улсын хэмжээнд)                                                             | 11.2          | 5.6              | -5.6     | 11.2                             | 5.6              | -5.6     |
| 5 | Стандарт, хэмжил зүйн салбарын улсын эталон болон хүнсний лабораториудын багаж, тоног төхөөрөмж (Улсын хэмжээнд)                             | 10.3          | 5.2              | -5.2     | 10.3                             | 5.2              | -5.2     |


Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

**Шинээр хэрэгжихээр батлагдсан 140 төсөл, арга хэмжээ хуульд заасан санхүүжилтийн шаардлагыг хангахгүй байна.**

Төсвийн тухай хуулийн “29.3.5 Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах” гэсэн заалтын дагуу эхний санхүүжилт буюу 2026 онд санхүүжих дүнг хуулийн дагуу батлаагүй нийт 140 төсөл, арга хэмжээ байна (Хавсралт 4). Эдгээр 140

төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжвэл зохих 982.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнг 407.5 тэрбум төгрөгөөр дутуу төлөвлөжээ. Төсвийн төсөлтэй харьцуулахад санхүүжилтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний тоо 65-аар өсөж, 2026 онд дутуу төлөвлөгдсөн санхүүжилтийн дүн 248.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

**Зураг 5. Монгол Улсын 2026 оны төсвийн санхүүжилтээр шинээр хэрэгжих санхүүжилтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний тоо, дутуу төлөвлөгдсөн санхүүжилт**



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

Санхүүжилтийн шаардлага хангаагүй, хамгийн өндөр төсөвт өртөг ба дутуу санхүүжих дүнтэй төсөл, арга хэмжээнүүдэд 234.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 43.6 тэрбум төгрөгийн дутуу санхүүжих дүнтэй “Хавдар судлалын Үндэсний төв-II” цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ, 231 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 56.9 тэрбум төгрөгийн дутуу санхүүжих дүнтэй Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замын 2 дугаар хэсгий төсөл багтаж байна. Мөн 178.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 23.5 тэрбум төгрөгийн дутуу санхүүжих дүнтэй Байгалийн түүхийн музейн үзүүлэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга,

үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж, 170.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 38.5 тэрбум төгрөгийн дутуу санхүүжих дүнтэй Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас (Хөшигийн хөндий) Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл, 108.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 23.4 тэрбум төгрөгийн дутуу санхүүжих дүнтэй Эрдэнэбүрэн-Мянгад чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээ 69 км ЦДАШ, 220/110/35 кВ-ын дэд станц, 106.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 21.2 тэрбум төгрөгийн дутуу санхүүжих дүнтэй Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл төслүүд багтаж байна.

**Хүснэгт 10. Төсвийн төсөлд туссан төсөвт өртөг ба 2026 онд олгох санхүүжилтийн дүнд хамгийн их өөрчлөлт орж батлагдсан шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүд (тэрбум төгрөг)**

| № | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил                                                                                              | Төсөвт өртөг  |                  |          | 2026 онд олгох санхүүжилтийн дүнд |                  |          |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|------------------|----------|-----------------------------------|------------------|----------|
|   |                                                                                                                                              | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                     | Батлагдсан төсөв | Өөрчлөлт |
| 1 | Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ (Улсын хэмжээнд) | 40.0          | 20.4             | -19.6    | 40.0                              | 20.4             | -19.6    |
| 2 | Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)                                  | 32.5          | 18.3             | -14.3    | 32.5                              | 18.3             | -14.3    |
| 3 | Гадаад харилцааны салбарын тоног төхөөрөмж (Улаанбаатар)                                                                                     | 19.9          | 9.9              | -9.9     | 19.9                              | 9.9              | -9.9     |
| 4 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж (Улсын хэмжээнд)                                                             | 11.2          | 5.6              | -5.6     | 11.2                              | 5.6              | -5.6     |
| 5 | Стандарт, хэмжил зүйн салбарын улсын эталон болон хүнсний лабораториудын багаж, тоног төхөөрөмж (Улсын хэмжээнд)                             | 10.3          | 5.2              | -5.2     | 10.3                              | 5.2              | -5.2     |

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль



## ӨМНӨХ ОНООС ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

**Төсвийн төсөлтэй харьцуулахад шилжих төсөл, арга хэмжээний тоо 12-оор, нийт төсөвт өртөг 233.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2026 онд олгох нийт санхүүжилтийн дүн 215 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан байна.**

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд нийт 7.61 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 442 шилжих төсөл, арга хэмжээг 1.97 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Төсвийн төсөлтэй харьцуулахад шилжих төсөл, арга хэмжээний тоо 12-оор, нийт төсөвт өртөг 233.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт санхүүжих дүн 215 тэрбум төгрөгөөр буурч батлагджээ.

Шилжих төсөл, арга хэмжээнүүдийг эдийн засгийн ангиллаар авч үзвэл 7.28 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.84 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 430 барилга байгууламж, 90.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 70.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 3 тоног төхөөрөмж, 224.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 55.8 тэрбум

төгрөгийн санхүүжих дүнтэй 5 их засвар, 11.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 3 ТЭЗҮ, 2.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 цахим системийг санхүүжүүлэхээр баталжээ. Шилжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн 95.7 хувийг барилга байгууламж, 1.2 хувийн тоног төхөөрөмж, 2.9 хувийг их засвар, 0.2 хувийг ТЭЗҮ, 0.03 хувийг цахим систем, нийт санхүүжилтийн 93.4 хувийг барилга байгууламж, 3.6 хувийг тоног төхөөрөмж, 2.8 хувийг их засвар, 0.1 хувийг ТЭЗҮ, 0.1 хувийг цахим систем тус тус эзэлж байна. Шилжих барилга, байгууламжийн 2026 онд санхүүжих дүн 201.4 тэрбум төгрөгөөр, шилжих их засварын 2026 онд санхүүжих дүн 13.7 тэрбум төгрөгөөр тус тус буурч батлагдсан байна.

**Хүснэгт 11. Монгол Улсын 2026 оны төсвөөс санхүүжүүлэх шилжих төсөл, арга хэмжээ, эдийн засгийн ангиллаар (тэрбум төгрөг)**

| Ангилал            | Төсөл, арга хэмжээний тоо |                  |          | Төсөвт өртөг  |                  |          | Төсөвт өртөгт эзлэх хувийн жин |                  | 2026 онд санхүүжих дүн |                  |          | 2026 онд санхүүжих дүнд эзлэх хувийн жин |                  |
|--------------------|---------------------------|------------------|----------|---------------|------------------|----------|--------------------------------|------------------|------------------------|------------------|----------|------------------------------------------|------------------|
|                    | Төсвийн төсөл             | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                  | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл          | Батлагдсан төсөв | Өөрчлөлт | Төсвийн төсөл                            | Батлагдсан төсөв |
| Барилга байгууламж | 418                       | 430              | +12      | 7046.9        | 7280.4           | +233.5   | 95.5%                          | 95.7%            | 2038.3                 | 1836.9           | -201.4   | 93.4%                                    | 93.4%            |
| Тоног төхөөрөмж    | 3                         | 3                | -        | 90.3          | 90.3             | -        | 1.2%                           | 1.2%             | 70.3                   | 70.3             | -        | 3.2%                                     | 3.6%             |
| Их засвар          | 5                         | 5                | -        | 224.2         | 224.2            | -        | 3.0%                           | 2.9%             | 69.5                   | 55.8             | -13.7    | 3.2%                                     | 2.8%             |
| ТЭЗҮ               | 3                         | 3                | -        | 11.5          | 11.5             | -        | 0.2%                           | 0.2%             | 2.0                    | 2.0              | -        | 0.1%                                     | 0.1%             |
| Цахим систем       | 1                         | 1                | -        | 2.4           | 2.4              | -        | 0.0%                           | 0.03%            | 1.9                    | 1.9              | -        | 0.1%                                     | 0.1%             |
| Нийт               | 430                       | 442              | +12      | 7375.2        | 7608.8           | +233.6   | 100%                           | 100%             | 2181.9                 | 1966.9           | -215.0   | 100%                                     | 100%             |

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль




**Боловсролын сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Эрүүл мэндийн сайд нарын шилжих төслийн тоо, төсөвт өртөг, 2026 онд олгох санхүүжилтийн дүн өөрчлөгдөж батлагджээ.**

Шилжих төсөл, арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл нийт төсөвт өртгийн 37.8 хувь Зам, тээврийн сайдад 16.2 хувь Боловсролын сайдад, 9.2 хувь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад, 8.8 хувь Эрчим хүчний сайдад, 7.9 хувь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад, 7.2 хувь Сангийн сайдад, 4.7 хувь Эрүүл мэндийн сайдад, үлдэх хувь нь бусад төсвийн ерөнхийлөн захирагчдад ногдож байна. Харин 2026 онд санхүүжих дүнгээр

авч үзвэл нийт санхүүжих дүнгийн 35.8 хувь хувь нь Зам, тээврийн сайдад, 17.5 хувь нь Боловсролын сайдад, 12 хувь нь Эрчим хүчний сайдад, 8.5 хувь нь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад, 5.4 хувь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад, 5.3 хувь нь Эрүүл мэндийн сайдад, 4.9 хувь нь Сангийн сайдад ногдож, үлдэх хувь нь бусад төсвийн ерөнхийлөн захирагчдад ногдож байна.

**Зураг 6. Монгол Улсын 2026 оны төсвөөс шилжих төсөл, арга хэмжээнд олгох санхүүжилтийн дүн, Төсвийн ерөнхийлөн захирагчаар (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

Төсвийн төсөлтэй харьцуулахад Боловсролын сайдын шилжих төсөл, арга хэмжээний тоо 9-өөр, нийт төсөвт өртөг 69.5 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 100 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын шилжих төсөл, арга хэмжээний тоо 1-ээр, нийт төсөвт өртөг 126.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт санхүүжих дүн 40.6 тэрбумаар буурч батлагдсан. Мөн Эрүүл мэндийн сайдын шилжих төсөл, арга хэмжээний тоо 1-ээр, нийт

төсөвт өртөг 30.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт санхүүжих дүн 3.1 тэрбум төгрөгөөр буурч батлагджээ. Зам, тээврийн сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Эрчим хүчний сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын ерөнхий прокурорын шилжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг өөрчлөгдөөгүй боловч санхүүжих дүн буурч батлагдсан байна.

**Хүснэгт 12. Монгол Улсын 2026 оны төсвөөс санхүүжүүлэх шилжих төсөл, арга хэмжээ, Төсвийн ерөнхийлөн захирагчаар (тэрбум төгрөг)**

| Төсвийн ерөнхийлөн захирагч                                       | Төсөл, арга хэмжээний тоо |                  | Төсөвт өртөг  |                  | Төсөвт өртөгт эзлэх хувийн жин |                  | 2026 онд санхүүжих дүн |                  | 2026 онд санхүүжих дүнд эзлэх хувийн жин |                  |
|-------------------------------------------------------------------|---------------------------|------------------|---------------|------------------|--------------------------------|------------------|------------------------|------------------|------------------------------------------|------------------|
|                                                                   | Төсвийн төсөл             | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл                  | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл          | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл                            | Батлагдсан төсөв |
| Зам, тээврийн сайд                                                | 60                        | 60               | 2878.1        | 2878.1           | 39.0%                          | 37.8%            | 794.9                  | 704.9            | 36.4%                                    | 35.8%            |
| Боловсролын сайд                                                  | 166                       | 175              | 1163.6        | 1233.1           | 15.8%                          | 16.2%            | 344.9                  | 345.0            | 15.8%                                    | 17.5%            |
| Эрчим хүчний сайд                                                 | 26                        | 26               | 669.7         | 669.7            | 9.1%                           | 8.8%             | 254.6                  | 236.1            | 11.7%                                    | 12.0%            |
| Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд                  | 33                        | 33               | 701.6         | 701.6            | 9.5%                           | 9.2%             | 195.6                  | 167.5            | 9.0%                                     | 8.5%             |
| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд                     | 56                        | 57               | 474.5         | 601.1            | 6.4%                           | 7.9%             | 147.5                  | 106.9            | 6.8%                                     | 5.4%             |
| Эрүүл мэндийн сайд                                                | 24                        | 25               | 324.8         | 355.2            | 4.4%                           | 4.7%             | 106.7                  | 103.6            | 4.9%                                     | 5.3%             |
| Сангийн сайд                                                      | 1                         | 1                | 546.6         | 546.6            | 7.4%                           | 7.2%             | 121.7                  | 96.3             | 5.6%                                     | 4.9%             |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга                                   | 6                         | 6                | 124.6         | 124.6            | 1.7%                           | 1.6%             | 60.3                   | 56               | 2.8%                                     | 2.8%             |
| Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд | 1                         | 1                | 154.5         | 154.5            | 2.1%                           | 2.0%             | 40.4                   | 40.4             | 1.8%                                     | 2.1%             |
| Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд                       | 16                        | 16               | 93.4          | 93.4             | 1.3%                           | 1.2%             | 29                     | 27.3             | 1.3%                                     | 1.4%             |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд                       | 8                         | 8                | 67.9          | 67.9             | 0.9%                           | 0.9%             | 24.7                   | 22.8             | 1.1%                                     | 1.2%             |
| Улсын ерөнхий прокурор                                            | 3                         | 3                | 65.4          | 65.4             | 0.9%                           | 0.9%             | 24.2                   | 22               | 1.1%                                     | 1.1%             |
| Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга       | 9                         | 10               | 41.7          | 48.7             | 0.6%                           | 0.6%             | 14.1                   | 15.2             | 0.6%                                     | 0.8%             |
| Хууль зүй, дотоод хэргийн сайд                                    | 9                         | 9                | 45.4          | 45.4             | 0.6%                           | 0.6%             | 13.8                   | 13.8             | 0.6%                                     | 0.7%             |
| Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд                     | 6                         | 6                | 9.3           | 9.3              | 0.1%                           | 0.1%             | 3.2                    | 3.2              | 0.1%                                     | 0.2%             |
| Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд                     | 4                         | 4                | 5.9           | 5.9              | 0.1%                           | 0.1%             | 2.6                    | 2.6              | 0.1%                                     | 0.1%             |
| Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч                                  | 1                         | 1                | 2.4           | 2.4              | 0.0%                           | 0.0%             | 1.9                    | 1.9              | 0.1%                                     | 0.1%             |
| Батлан хамгаалахын сайд                                           | 1                         | 1                | 5.9           | 5.9              | 0.1%                           | 0.1%             | 2.1                    | 1.5              | 0.1%                                     | 0.1%             |

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

### Аймгуудад байршилтай шилжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг нэмэгдэж батлагдсан байна.

Шилжих төсөл, арга хэмжээг байршлаар нь авч үзвэл нийт төсөвт өртгийн 54.7 хувь аймгуудад, 19.3 хувь Улаанбаатар хотод, 19.1 хувь бүсүүдэд, 7.2 хувь улсын хэмжээнд батлагджээ. Харин 2026 онд санхүүжих дүнгээр авч үзвэл нийт санхүүжих дүнгийн 61.0 хувь аймгуудад, 19.9 хувь Улаанбаатар хотод, 14.1 бүсүүдэд, 4.9 хувь улсын хэмжээнд ногдож байна.

Төсвийн төсөлтэй харьцуулахад Улаанбаатар хотын шилжих төсөл, арга хэмжээний тоо 1-ээр, нийт төсөвт өртөг 122.5 тэрбум төгрөгөөр

нэмэгдэж, нийт санхүүжих дүн 65.1 тэрбум төгрөгөөр буурсан байна. Аймгуудын шилжих төсөл, арга хэмжээний тоо 11-ээр, нийт төсөвт өртөг 111 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт санхүүжих дүн 59.5 тэрбум төгрөгөөр буурсан. Бүсүүдийн шилжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй бөгөөд нийт санхүүжих дүн 64.9 тэрбум төгрөгөөр буурсан. Улсын хэмжээний шилжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөгт өөрчлөлт ороогүй бөгөөд нийт санхүүжих дүн 25.4 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан байна.

### Хүснэгт 13. Монгол Улсын 2026 оны төсвөөс санхүүжүүлэх шилжих төсөл, арга хэмжээ, байршлаар (тэрбум төгрөг)

| Байршил        | Төсөл, арга хэмжээний тоо |                  | Төсөвт өртөг  |                  | Төсөвт өртөгт эзлэх хувийн жин |                  | 2026 онд санхүүжих дүн |                  | 2026 онд санхүүжих дүнд эзлэх хувийн жин |                  |
|----------------|---------------------------|------------------|---------------|------------------|--------------------------------|------------------|------------------------|------------------|------------------------------------------|------------------|
|                | Төсвийн төсөл             | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл                  | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл          | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл                            | Батлагдсан төсөв |
| Аймгуудад      | 354                       | 365              | 4034.0        | 4145.0           | 54.7%                          | 54.5%            | 1259.7                 | 1200.2           | 57.7%                                    | 61.0%            |
| Улаанбаатар    | 58                        | 59               | 1342.3        | 1464.8           | 18.2%                          | 19.3%            | 457.3                  | 392.2            | 21.0%                                    | 19.9%            |
| Бүсүүдэд       | 17                        | 17               | 1452.4        | 1452.4           | 19.7%                          | 19.1%            | 343.1                  | 278.2            | 15.7%                                    | 14.1%            |
| Улсын хэмжээнд | 1                         | 1                | 546.6         | 546.6            | 7.4%                           | 7.2%             | 121.7                  | 96.3             | 5.6%                                     | 4.9%             |


Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

### Хан-Уул дүүрэгт байршилтай шилжих төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, 2026 онд олгох санхүүжилтийн дүн харьцангуй өндөр дүнгээр өөрчлөгдөж батлагджээ.

Улаанбаатар хотод батлагдсан шилжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн 31.9 хувь Хан-Уул дүүрэгт 17.9 хувь хэрэгжих тодорхой дүүрэг заагаагүй төсөл, арга хэмжээнд, 17.2 хувь Сүхбаатар дүүрэгт ногдож, бусад дүүргүүдэд харьцангуй бага хувь ногдож байна. Харин

2026 онд санхүүжих дүнгээр авч үзвэл нийт санхүүжих дүнгийн 33.1 хувь Хан-Уул дүүрэгт, 15.7 хувь хэрэгжих тодорхой дүүрэг заагаагүй төсөл, арга хэмжээнд, 16 хувь Сүхбаатар дүүрэгт ногдож, бусад дүүргүүдэд харьцангуй бага хувь ногдож байна.

**Зураг 7. Монгол Улсын 2026 оны төсвөөс шилжих төсөл, арга хэмжээнд олгох санхүүжилтийн дүн, дүүргээр (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

Төсвийн төсөлтэй харьцуулахад Хан-Уул дүүргийн шилжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг 94.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт санхүүжих дүн 46.4 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан. Баянгол дүүргийн шилжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг 27.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт санхүүжих дүн 0.7 тэрбум төгрөгөөр буурсан. Налайх дүүргийн шилжих төсөл арга, хэмжээний нийт

төсөвт өртөг 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт санхүүжих дүн 1.8 тэрбум төгрөгөөр буурсан. Баянзүрх дүүргийн шилжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг 0.6 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 1.9 тэрбум төгрөгөөр буурсан. Сүхбаатар, Багануур дүүргүүдийн шилжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг өөрчлөгдөөгүй ч нийт санхүүжих дүн буурч батлагдсан байна.

**Хүснэгт 14. Монгол Улсын 2026 оны төсвөөс санхүүжүүлэх Улаанбаатар хотын шилжих төсөл, арга хэмжээ, дүүргээр (тэрбум төгрөг)**

| Байршил        | Төсөл, арга хэмжээний тоо |                  | Төсөвт өртөг  |                  | Төсөвт өртөгт эзлэх хувийн жин |                  | 2026 онд санхүүжих дүн |                  | 2026 онд санхүүжих дүнд эзлэх хувийн жин |                  |
|----------------|---------------------------|------------------|---------------|------------------|--------------------------------|------------------|------------------------|------------------|------------------------------------------|------------------|
|                | Төсвийн төсөл             | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл                  | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл          | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл                            | Батлагдсан төсөв |
| Хан-Уул        | 8                         | 8                | 373           | 467.7            | 27.8%                          | 31.9%            | 176.2                  | 129.8            | 38.5%                                    | 33.1%            |
| Сүхбаатар      | 9                         | 9                | 251.4         | 251.4            | 18.7%                          | 17.2%            | 71.3                   | 62.9             | 15.6%                                    | 16.0%            |
| Нийслэл        | 4                         | 4                | 262.8         | 262.8            | 19.6%                          | 17.9%            | 64.1                   | 61.7             | 14.0%                                    | 15.7%            |
| Баянгол        | 6                         | 7                | 71.7          | 99.1             | 5.3%                           | 6.8%             | 35.3                   | 34.6             | 7.7%                                     | 8.8%             |
| Баянзүрх       | 11                        | 11               | 108.8         | 108.2            | 8.1%                           | 7.4%             | 35.7                   | 33.8             | 7.8%                                     | 8.6%             |
| Багануур       | 5                         | 5                | 73.8          | 73.8             | 5.5%                           | 5.0%             | 31.3                   | 27.8             | 6.9%                                     | 7.1%             |
| Налайх         | 3                         | 3                | 72.2          | 73.3             | 5.4%                           | 5.0%             | 17.9                   | 16.1             | 3.9%                                     | 4.1%             |
| Сонгинохайрхан | 6                         | 6                | 87.1          | 87.1             | 6.5%                           | 5.9%             | 14                     | 14               | 3.1%                                     | 3.6%             |
| Багахангай     | 2                         | 2                | 16.3          | 16.3             | 1.2%                           | 1.1%             | 6.1                    | 6.1              | 1.3%                                     | 1.6%             |
| Чингэлтэй      | 4                         | 4                | 25.1          | 25.1             | 1.9%                           | 1.7%             | 5.3                    | 5.3              | 1.2%                                     | 1.4%             |

\*Хэрэгжих тодорхой дүүрэг заагаагүй төсөл, арга хэмжээ


Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

**Төв, Хөвсгөл, Орхон, Дорнод аймгуудын шилжих төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн харьцангуй өндөр дүнгээр өөрчлөгдөж батлагдсан.**

Аймгуудад батлагдсан шилжих, төсөл арга хэмжээний нийт төсөвт өртгийн 17.5 хувь Хэнтий аймагт, 13.7 хувь Төв аймагт, 9.1 хувь Дорнод аймагт, 7.7 хувь Ховд аймагт, 5.6 хувь Архангай аймагт, 5.4 хувь Хөвсгөл аймагт, 5.1 хувь Дархан-Уул аймагт, 5 хувь Баянхонгор аймагт, 5 хувь Завхан аймагт ногдож, бусад аймгуудад 5 хувиас бага хувь ногдож байна.

Харин 2026 онд санхүүжих дүнгээр авч үзвэл нийт санхүүжих дүнгийн 14.5 хувь Төв аймагт, 12 хувь Хэнтий аймагт, 8.2 хувь Дорнод аймагт, 7.4 хувь Баянхонгор аймагт, 7 хувь Ховд аймагт, 6.7 хувь Өвөрхангай аймагт, 6.2 хувь Завхан аймагт, 5.6 хувь Дархан-Уул аймагт ногдож, бусад аймгуудад 5 хувиас бага ногдож байна.

**Зураг 8. Монгол Улсын 2026 оны төсвөөс шилжих төсөл, арга хэмжээнд олгох санхүүжилтийн дүн, аймгаар (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

Төсвийн төсөлтэй харьцуулахад Төв аймгийн шилжих төсөл, арга хэмжээний тоо 1-ээр, нийт төсөвт өртөг 29.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт санхүүжих дүн 0.1 тэрбум төгрөгөөр буурсан. Хөвсгөл аймгийн шилжих төсөл, арга хэмжээний тоо 3-аар, нийт төсөвт өртөг 29.7 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 4.4 тэрбум төгрөгөөр, Орхон аймгийн шилжих төсөл, арга хэмжээний тоо 2-оор нийт төсөвт өртөг 11.8 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 2.8 тэрбум төгрөгөөр, Өвөрхангай аймгийн

шилжих төсөл, арга хэмжээний тоо 2-оор, нийт төсөвт өртөг 9.3 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 1.2 тэрбум төгрөгөөр, Сэлэнгэ аймгийн шилжих төсөл, арга хэмжээний тоо 1-ээр, нийт төсөвт өртөг 7.7 тэрбум төгрөгөөр, нийт санхүүжих дүн 1.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж батлагдсан. Дорнод аймгийн шилжих төсөл, арга хэмжээний тоо, төсөвт өртөг өөрчлөгдөөгүй ч нийт санхүүжих дүн 13.5 тэрбум төгрөгөөр буурсан.

**Хүснэгт 15. Монгол Улсын 2026 оны төсвөөс санхүүжүүлэх аймгуудад байршилтай шилжих төсөл, арга хэмжээ (тэрбум төгрөг)**

| Байршил                  | Төсөл, арга хэмжээний тоо |                  | Төсөвт өртөг  |                  | Төсөвт өртөгт эзлэх хувийн жин |                  | 2026 онд санхүүжих дүн |                  | 2026 онд санхүүжих дүнд эзлэх хувийн жин |                  |
|--------------------------|---------------------------|------------------|---------------|------------------|--------------------------------|------------------|------------------------|------------------|------------------------------------------|------------------|
|                          | Төсвийн төсөл             | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл                  | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл          | Батлагдсан төсөв | Төсвийн төсөл                            | Батлагдсан төсөв |
| Төв                      | 21                        | 22               | 538           | 567.6            | 13.3%                          | 13.7%            | 174.7                  | 174.6            | 13.9%                                    | 14.5%            |
| Хэнтий                   | 27                        | 27               | 725.9         | 725.9            | 18.0%                          | 17.5%            | 169.8                  | 144.1            | 13.5%                                    | 12.0%            |
| Дорнод                   | 11                        | 11               | 375.8         | 375.8            | 9.3%                           | 9.1%             | 111.7                  | 98.2             | 8.9%                                     | 8.2%             |
| Баянхонгор               | 17                        | 17               | 205.3         | 208.4            | 5.1%                           | 5.0%             | 95.7                   | 89.2             | 7.6%                                     | 7.4%             |
| Ховд                     | 23                        | 23               | 319.1         | 320.1            | 7.9%                           | 7.7%             | 90.8                   | 84.3             | 7.2%                                     | 7.0%             |
| Өвөрхангай               | 22                        | 24               | 181.2         | 190.5            | 4.5%                           | 4.6%             | 78.7                   | 79.9             | 6.2%                                     | 6.7%             |
| Завхан                   | 34                        | 34               | 201           | 207              | 5.0%                           | 5.0%             | 74.7                   | 74.4             | 5.9%                                     | 6.2%             |
| Дархан-Уул               | 19                        | 19               | 213.2         | 213.2            | 5.3%                           | 5.1%             | 71.7                   | 66.9             | 5.7%                                     | 5.6%             |
| Архангай                 | 27                        | 27               | 229.8         | 230.6            | 5.7%                           | 5.6%             | 61.4                   | 59.3             | 4.9%                                     | 4.9%             |
| Хөвсгөл                  | 33                        | 36               | 194           | 223.7            | 4.8%                           | 5.4%             | 51.1                   | 55.5             | 4.1%                                     | 4.6%             |
| Увс                      | 17                        | 17               | 124.8         | 124.8            | 3.1%                           | 3.0%             | 50.3                   | 49               | 4.0%                                     | 4.1%             |
| Говь-Алтай               | 20                        | 21               | 136.1         | 141.4            | 3.4%                           | 3.4%             | 41.7                   | 39.2             | 3.3%                                     | 3.3%             |
| Баян-Өлгий               | 12                        | 12               | 112.6         | 112.6            | 2.8%                           | 2.7%             | 37.8                   | 37.8             | 3.0%                                     | 3.2%             |
| Сэлэнгэ                  | 11                        | 12               | 68            | 75.7             | 1.7%                           | 1.8%             | 25.7                   | 27.4             | 2.0%                                     | 2.3%             |
| Булган                   | 18                        | 18               | 86.3          | 86.3             | 2.1%                           | 2.1%             | 25.9                   | 25.9             | 2.1%                                     | 2.2%             |
| Сүхбаатар                | 14                        | 14               | 88.8          | 91.9             | 2.2%                           | 2.2%             | 24                     | 23.9             | 1.9%                                     | 2.0%             |
| Говьсүмбэр               | 8                         | 8                | 59.8          | 59.8             | 1.5%                           | 1.4%             | 18.4                   | 18.4             | 1.5%                                     | 1.5%             |
| Өмнөговь                 | 5                         | 5                | 29.5          | 29.5             | 0.7%                           | 0.7%             | 16.8                   | 16.4             | 1.3%                                     | 1.4%             |
| Орхон                    | 5                         | 7                | 39.6          | 51.4             | 1.0%                           | 1.2%             | 13.4                   | 16.2             | 1.1%                                     | 1.4%             |
| Дорноговь                | 4                         | 5                | 43.7          | 46.8             | 1.1%                           | 1.1%             | 12.7                   | 11.3             | 1.0%                                     | 0.9%             |
| Дундговь                 | 5                         | 5                | 61.3          | 61.9             | 1.5%                           | 1.5%             | 12.7                   | 7.9              | 1.0%                                     | 0.7%             |
| Дархан-Уул, Сэлэнгэ, Төв | 1                         | 1                | 0.3           | 0.3              | 0.0%                           | 0.0%             | 0.3                    | 0.3              | 0.0%                                     | 0.0%             |

Эх сурвалж: Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль

**Төсвийн төсөлд тусаагүй байсан 12 шилжих төслийг УИХ-аас нэмж баталжээ.**

Төсвийн төсөлд тусгаагүй байсан 4 нэмэгдэж батлагдсан нийт 115.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 15.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 12 шилжих төсөл, арга хэмжээ байна (Хавсралт 5). Үүнд, 2018 онд хэрэгжих эхэлсэн 1, 2019 онд хэрэгжиж эхэлсэн 2, 2020 онд хэрэгжиж эхэлсэн 1, 2021 онд хэрэгжиж эхэлсэн 1, 2022 онд хэрэгжиж эхэлсэн 3, 2024 онд хэрэгжиж эхэлсэн 4 төсөл, арга хэмжээ багтжээ. Эдгээрээс хамгийн өндөр төсөвт өртөг ба санхүүжих дүнтэй төслүүдийг дурдвал, 29.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 1.6

тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Монголын Үндэсний археологи, палеонтологи, угсаатны музей, лаборатори, 27.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 3.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Эх хүүхдийн Эрүүл мэндийн Үндэсний төвийн “Хүүхдийн зөвлөх поликлиник”-ийн барилгын өргөтгөл, 14.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 0.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн барилга, спорт заал багтаж байна.

## Төсвийн төсөлд туссан 97 шилжих төслийн төсөвт өртөг эсвэл 2026 онд олгох санхүүжилтийн дүнд өөрчлөлт орж батлагджээ.

Төсвийн төсөлд туссан төсөвт өртөг эсвэл санхүүжих дүн нь өөрчлөгдөж батлагдсан 97 төсөл, арга хэмжээ байна. (Хавсралт 6). Эдгээр 97 төсөл, арга хэмжээний санхүүжих дүн бүгд өөрчлөгдсөн ба 18 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэж, 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг буурч батлагдсан. Төсөвт өртөг ба санхүүжих дүнд өндөр дүнтэй өөрчлөлт орсон төсөл, арга хэмжээнүүдээс дурдвал, Байгалийн түүхийн музейн барилгын төсөвт өртөг 94.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, санхүүжих дүн 36 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан. Мөн Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалтын санхүүжих дүн 25.4 тэрбум төгрөгөөр, Бүсүүдийн хөгжлийг дэмжих

инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах улсын төсвийн хөрөнгийн санхүүжих дүн 13.1 тэрбум төгрөгөөр, Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай 179.7 км авто замын санхүүжих дүн 13 тэрбум төгрөгөөр, Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай 124.5 км авто замын санхүүжих дүн 12.9 тэрбум төгрөгөөр, Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай 156 км авто замын их засварын санхүүжих дүн 11.4 тэрбум төгрөгөөр, Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай 152.5 км авто замын санхүүжих дүн 10.8 тэрбум төгрөгөөр тус тус буурч батлагджээ.

### Хүснэгт 16. Төсвийн төсөлд туссан төсөвт өртөг ба 2026 онд олгох санхүүжилтийн дүн нь хамгийн их дүнгээр өөрчлөгдөж батлагдсан шилжих төсөл, арга хэмжээнүүд (тэрбум төгрөг)

| №  | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил                                                 | Эхлэх огноо | Дуусах огноо | Төсөвт өртөг |         |          | Төсөвт өртгийн өөрчлөлт | 2026 онд санхүүжих дүнгийн өөрчлөлт |
|----|-------------------------------------------------------------------------------------------------|-------------|--------------|--------------|---------|----------|-------------------------|-------------------------------------|
|    |                                                                                                 |             |              | Анхны        | Сүүлийн | 2026 онд |                         |                                     |
| 1  | Байгалийн түүхийн музейн барилга (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)                                  | 2020        | 2028         | 94.5         | 130.6   | 225.3    | 94.7                    | -36.0                               |
| 2  | Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал (Завхан, Улиастай сум)                                 | 2024        | 2027         | 11.7         | 11.7    | 15.3     | 3.6                     | 1.0                                 |
